



“ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ” ХХК-ИЙН

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

WORLDWIDE FINANCE AUDIT Co.,Ltd

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
25-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн
гудамж UB TOWER 9 давхар 903тоот
Утас: +976- 99117973

2023.03.23 № 06 - 2022/03

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид "ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ" ХХК-ийн 2022 оны 12-р сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлан нь "ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ" ХХК-ийн 2022 оны 12-р сарын 31- ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага” гэсэн хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд тохиромжтой гэж бид үзэж байна.

Санхүүгийн тайлангийн талаархи Удирдлагын үүрэг, хариуцлага

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах болон зальт ажиллагаа буюу алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс ангид байдлаар санхүүгийн тайланг бэлтгэх боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай гэж удирдлагын үзсэн дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага юм.



Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр сонголт байхгүйгээс бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.


Удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний хариуцлага бол хийсэн аудитын ажилдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах явдал билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Аудитын Олон Улсын Стандартын дагуу бид санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи хүчин төгөлдөр, хангалттай нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх болон ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөх ёстой.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн, тодруулгын талаархи аудитын нотолгоог олж авахын тулд гүйцэтгэх горимуудыг агуулдаг. Сонгох горимууд нь аудиторын мэргэжлийн шүүн тунгаалт, түүнчлэн алдаа буюу зальт ажиллагааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь уг компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш, харин тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг төлөвлөхийн тулд санхүүгийн тайлангийн бэлтгэлт, үнэн зөв толилуулгад хамааралтай дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн удирдлагын хийсэн материаллаг тооцоолол, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зарчим болон санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явцад үнэлсэн.

Санхүүгийн аудитын үед аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг "ХАВСРАЛТ"-д толилуулав. Энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл бидний аудиторын тайлангийн нэг хэсэг болно.



ХАВСРАЛТ - Аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж хэрэглэж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурь баримталдаг. Түүнчлэн бид:

- Санхүүгийн тайлангуудын залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг тодорхойлж, үнэлээд, эдгээр эрсдэлд тохирсон аудитын горим зохиож, гүйцэтгэснээр дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо олж авдаг.
Залилан хуйвалдаан, хууран мэхлэлт, санаатай оригдуулалт, буруу толилуулга, дотоод хяналтыг үл ойшоох зэрэгтэй холбоотой байдаг учраас залилангаас үүдсэн материаллаг буруу илэрхийлэл илрэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийлэл илрэхгүй байх эрсдлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг зохиох зорилгоор аудитад хамаатай дотоод хяналтын ойлголтыг олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой байдал, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Тасралтгүй ажиллагааг үргэлжлүүлэх компанийн чадамжид томоохон эргэлзээ үүсгэхээр материаллаг тодорхой бус байдал агуулсан холбогдох үйл явдал болон нөхцөл байгаа эсэх талаарх олж авсан нотолгоондоо суурилан нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмын удирдлагын хэрэглээний зохистой байдлыг дүгнэдэг. Материаллаг тодорхой бус байдал байна гэж бид дүгнэсэн бол санхүүгийн тайланд оруулсан тодруулгатай холбоотой анхаарал хандуулсан хэсгийг аудиторын тайланд оруулах эсвэл тухайн тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлага гардаг. Бидний дүгнэлт аудитын тайланг огноолсон өдөр хүртэлх хугацаанд олж авсан нотолгоон дээр суурилдаг. Түүнчлэн ирээдүйд болох үйл явдал, нөхцлүүд нь компанийг тасралтгүй ажиллагаагаа зогсооход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, тодруулга, бүтэц, агуулга, санхүүгийн тайлангууд нь шударгаар толилуулах зорилгоо хангах тохирсон аргаар үндсэн ажил гүйлгээ болон үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүдэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар удирдлагатай харилцдаг.



Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

/ мян.төгрөг /

Балансын зүйл	2021 он	2022 он
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
<i>Мөнгөн хөрөнгө</i>	<u>480,113.5</u>	<u>299,598.8</u>
Касс дахь бэлэн мөнгө	105,955.3	258,940.2
Банкин дахь мөнгө	374,158.2	40,658.6
<i>Зээл /цэврээр /</i>	<u>6,355,905.3</u>	<u>5,568,833.3</u>
<i>Нийт зээл</i>	<u>6,355,905.3</u>	<u>5,573,833.3</u>
Хэвийн зээл	6,355,905.3	5,473,833.3
Хугацаа хэтэрсэн зээл	-	100,000.0
<i>Зээлийн эрсдлийн сан</i>	-	(5,000.0)
<i>Бусад авлага</i>	<u>2,162,392.2</u>	<u>3,052,730.1</u>
Хуримтлуулан тооцсон хүүгийн авлага	2,144,305.2	3,024,706.5
Бусад авлага	18,087.0	28,023.6
<i>Бусад хөрөнгө</i>	<u>44,258.3</u>	<u>37,413.2</u>
Урьдчилж төлсөн тооцоо	36,588.3	28,786.3
Материал, үнэ бүхий зүйлс	7,670.0	7,670.0
Бусад	-	956.9
Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>9,042,669.3</u>	<u>8,958,575.4</u>
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	109,914.5	126,562.9
Биет бус хөрөнгө	939,508.1	1,081,965.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>1,049,422.6</u>	<u>1,208,528.4</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,092,091.9	10,167,103.8
ӨР ТӨЛБӨР		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>	<u>1,765,911.9</u>	<u>100,000.0</u>
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	257,951.8	-
Өрийн бичгээрх өглөг	1,507,960.1	100,000.0
<i>Бусад эх үүсвэр</i>	<u>2,540,000.0</u>	<u>2,504,149.3</u>
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,540,000.0	2,504,149.3
<i>Бусад өр төлбөр</i>	<u>132,060.5</u>	<u>29,248.4</u>
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	103,025.6	-
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг	29,034.9	24,394.7
Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн өглөг	-	4,853.7
<i>Бусад өглөг</i>	<u>30,172.3</u>	<u>49,078.0</u>
Цалингийн өглөг	-	448.6
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	4.7	-
ХАОАТ-ын өглөг	9,909.2	35,529.7
Орлогын албан татварын өглөг	9,746.9	986.4
Бусад өглөг	10,511.5	12,113.3
<i>Урт хугацаат өр төлбөр</i>	<u>2,448,802.5</u>	<u>4,291,168.3</u>
Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	2,448,802.5	4,291,168.3
Нийт өр төлбөрийн дүн	<u>6,916,947.2</u>	<u>6,973,644.0</u>
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
Эздийн өмч	-	-
Энгийн хувьцаа	2,500,000.0	2,500,000.0
Хуримтлагдсан ашиг	675,144.7	693,459.8
Эздийн өмчийн дүн	<u>3,175,144.7</u>	<u>3,193,459.8</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	10,092,091.9	10,167,103.8



Аудитлагдсан Орлого үр дүнгийн тайлан


/ мян.төгрөг /

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021 он	2022 он
ХҮҮГИЙН ОРЛОГО	1,357,957.9	1,596,820.9
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	1,362,126.7	1,596,820.9
Харилцах дансны хүүгийн орлого	19.5	
Хүүгийн орлогын буцаалт	(4,188.3)	
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	328,553.8	544,918.6
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО	1,029,404.1	1,051,902.3
ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	77,267.2	114,940.2
Гадаад валютын ханшийн тэгшилтгэлийн орлого	368.9	9,692.6
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	76,898.3	105,247.6
ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	1,003,933.0	1,141,878.9
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал		
Гадаад валютын ханшийн тэгшилтгэлийн зардал	369.9	255.2
Боловсон хүчний холбогдолтой зардал		
Үндсэн болон нэмэгдэл цалин	186,512.2	284,599.3
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	22,212.7	35,948.5
Сургалтын зардал	60.0	1,130.7
Бусад зардал		
Зээлийн авлага барагдуулахтай холбоотой гарсан зардал	724.8	3,392.3
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбондоо гарсан	428,211.2	363,998.1
Аудитын төлбөр, мэргжэлийн үйлчилгээ	7,500.0	17,560.0
Даатгал		106.9
Түрээс	5,490.3	9,770.9
Ашиглалтын зардал	273.0	
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	52,003.7	74,067.5
Харилцаа холбоо, интернет	27,598.4	29,973.0
Шатахуун болон тээврийн зардал	3,094.9	7,221.6
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ		2,032.5
Зохицуулалтын хураамжийн зардал	2,880.0	3,600.0
Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал	3,830.5	745.9
Захиалгат хэвлэлийн зардал		401.3
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	21,321.2	31,850.1
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	93,608.4	39,204.1
Бичиг хэргийн зардал	328.0	1,013.9
Ариун цэврийн зардал		249.4
Бусад зардал	147,913.8	234,757.7
ХҮҮГИЙН БУС АШИГ /АЛДАГДАЛ /	(926,665.8)	(1,026,938.7)
ЭРСДЛИЙН ЗАРДАЛ	-	5,000.0
Зээлийн эрсдлийн зардал		5,000.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ /АЛДАГДАЛ /	102,738.3	19,963.6
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	33,842.4	-
Бусад орлого	33,842.4	
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,229.5	662.1
Зочин төлөөлөгчийн зардал		351.5
Торгуулийн зардал		146.0
Хөрөнгө данснаас хассаны гарз	1,229.5	
Бусад зардал	2,000.0	164.6
ҮНДСЭН БУС АШИГ /АЛДАГДАЛ/ ДҮН	30,612.9	(662.1)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ АЛДАГДАЛ	133,351.2	19,301.5
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ	10,598.3	986.4
ЦЭВЭР АШИГ /АЛДАГДАЛ /	122,752.9	18,315.1



Аудитлагдсан Өмчийн өөрлөлтийн тайлан

Зүйл	/ мян.төгрөг /		
	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,500,000.0	552,391.8	3,052,391.8
Алдааны залруулга			-
Залруулсан үлдэгдэл	2,500,000.0	552,391.8	3,052,391.8
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		122,752.9	122,752.9
Өмчид гарсан өөрчлөлт			-
Зарласан ноогдол ашиг			-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,500,000.0	675,144.7	3,175,144.7
Алдааны залруулга			-
Залруулсан үлдэгдэл	2,500,000.0	675,144.7	3,175,144.7
Тайлант үеийн цэвэр ашиг		18,315.1	18,315.1
Өмчид гарсан өөрчлөлт			-
Зарласан ноогдол ашиг			-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,500,000.0	693,459.8	3,193,459.8



Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

/ мян.төгрөг /

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он	2022 он
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</i>	8,972,075.7	13,020,400.9
Зээлийн хүүгийн орлого	1,362,126.7	703,323.5
Харилцах дансны хүүгийн орлого	19.5	
Гадаад валютын ханшийн зөрүү	(1.0)	
Итгэлцлийн үйлчилгээний орлого	2,114,000.0	3,270,129.8
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	76,898.3	105,247.6
Хүүгийн орлогын буцаалт	(4,188.3)	
Бусад үйлчилгээний орлого	5,423,220.5	8,941,700.0
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</i>	8,899,366.8	13,199,935.4
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал		407,506.2
Өрийн бичгийн хүүгийн зардал	278,637.6	100,158.3
Үндсэн ба нэмэгдэл цалин	186,512.2	228,106.8
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	22,212.7	64,518.5
Албан томилолт, сургалтын зардал	60.0	302.4
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	273.0	
Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн	30,693.3	5,278.3
Бичиг хэрэг, ариун цэврийн зардал	328.0	46.5
Татвар, даатгалд төлсөн мөнгө	147,783.0	74,777.0
Зар сурталчилгаанд төлсөн	93,608.4	29,631.2
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	37,313.1	7,437.7
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан	428,211.1	2,062,995.7
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээний	31,601.4	386,420.8
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	2,880.0	3,600.0
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	7,484,798.6	6,063,219.0
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	154,454.4	3,765,937.0
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</i>	72,708.9	(179,534.5)
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<i>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого</i>	33,842.4	-
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого		
Бусад	33,842.4	
<i>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага</i>	3,229.5	980.2
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал		405.2
Торгуулийн зардал		146.0
Бусад	3,229.5	429.0
<i>Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</i>	30,612.9	(980.2)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	103,321.8	(180,514.7)
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	376,791.7	480,113.5
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	480,113.5	299,598.8

